



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 01.25

Улаанбаатар хот

ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаа,
санхүүгийн үйл ажиллагаанд
өгсөн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9-дэх хэсэг, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТКТ-02.25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 1 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн 2713621 санал буюу 99,9%-ийн саналаар ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах, 2713621 санал буюу 99,9%-ийн саналаар Аудитын байгууллагаас компанийн санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг тус тус батласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, компанийн өртөг зардлыг бууруулах, ашгийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөгөөр тавьсан зорилтыг биелүүлэх бодитой арга хэмжээг хэрэгжүүлэн, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.


Хурлын дарга

АРИГ ГАЛ
ХК
151803-287578

А.ТӨМӨР-ОЧИР

Тооллогын комиссын дарга

П.ЦЭРЭН-ОЧИР



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 02.25

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож,
батлах тухай.

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт , “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02.25 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 2 дугаарт заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив

2,724,582 санал буюу 11,15%-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
2,712,791 санал буюу 11,1 %-ийн саналаар Б.Ёндонжамцыг,
2,712,809 санал буюу 11,1 %-ийн саналаар Х.Мөнхтуяаг,
2,712,881 санал буюу 11,1 %-ийн саналаар С.Алимааг,
2,713,016 санал буюу 11,1 %-ийн саналаар Х.Ханияаг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,

2,712,791 санал буюу 11,1%-ийн саналаар Б.Аюушийг,
2,712,791 санал буюу 11,1%-ийн саналаар Б.Болдыг,
2,712,808 санал буюу 11,1%-ийн саналаар З.Сүхбаатарыг,
2,712,791 санал буюу 11,1%-ийн саналаар Э.Бямбажавыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгох

тус сонгосныг баталсугай.

2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (С.Мөнхжаргал)- д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

А.ТӨМӨР-ОЧИР

Тооллогын комиссын дарга

П.ЦЭРЭН-ОЧИР



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 03.25

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2025- оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06.24 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТКТ-02.24 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дугаарт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2713621 санал буюу 99,9 %-ийн саналаар ТУЗ-ийн 2025 оны 2 сарын 20-ны өдрийн 06.24 тоот тогтоолоор баталсан 2024 оны цэвэр ашгийн 13.0%-иар буюу нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийг 100.00 төг-өөр (нэг зуун төгрөг 00 мөнгө)-өөр баталсан шийдвэрийг дэмжсүгэй.

2. Ногдол ашигт зарцуулагдах 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилагдах ногдол ашигт зарцуулагдах 338,933.1 мянган төгрөг (гурван зуун гучин найман сая есөн зуун гучин гурван мянга нэг зуун)-ийг компанийн ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д зөвшөөрсүгэй.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу ногдол ашгийг 2025 оны 4 дугаар сарын 30-ны дотор нийтэд зарлан тараах ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай.

Хурлын дарга

А.ТӨМӨР-ОЧИР

Тооллогын комиссын дарга

П.ЦЭРЭН-ОЧИР



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 04.25

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 хэсэг, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТКТ-02.25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын 2025 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигч дийн 2713621 санал буюу 99,9 %-ийн саналаар 58,000.0 мян.₮ (Тавин найман сая)-өөр баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжаргал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

А.ТӨМӨР-ОЧИР

Тооллогын комиссын дарга

П.ЦЭРЭН-ОЧИР



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 05.25

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг
урамшуулах зөвшөөрөл олгох
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 хэсэг, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТКТ-02.25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2713621 буюу 99,9%-ийн саналаар 2024 оны үйл ажиллагааны ашгаас ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал олгох тухай гүйцэтгэх удирдлагаас оруулсан саналыг дэмжсүгэй.
2. ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллыг хавсралтын дагуу баталсугай.
3. Урамшуулалд зарцуулах 20.0 сая.төгрөг (хорин сая)-ийг компанийн ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга

 А.ТӨМӨР-ОЧИР

 П.ЦЭРЭН-ОЧИР



“ АРИГ ГАЛ ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын
30- ны өдөр

Дугаар 06.25

Улаанбаатар хот

Компанийн гаргасан хувьцааг
халааслах зөвшөөрөл олгох
тухай.

Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 49 дүгээр зүйлийн 49.1, 62 дугаар зүйлийн 62.1.12 дахь хэсгийг удирдлага болгон, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТКТ-02.24 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.24 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал оролцогчдын 2713621 буюу 99,9%-ийн саналаар компанийн гаргасан хувьцаанаас "Компанийн тухай хууль"-ийн 49 дүгээр зүйлийн 49.2 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд багтаан биржийн арилжаагаар худалдан авч халааслахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа халааслахад шаардлагатай хөрөнгийг компанийн үйл ажиллагааны бус зардлаас гаргасугай.
3. Компанийн гаргасан хувьцаа халааслахад шаардлагатай хөрөнгийг тухай бүр ТУЗ-д оруулан батлуулж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, хувьцаа халааслах үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-д тус тус үүрэг болгосугай.

Хурлын дарга



А.ТӨМӨР-ОЧИР

Тооллогын комиссын дарга

П.ЦЭРЭН-ОЧИР